



## АТАР-ӨРГӨӨ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 17 өдөр

№ 25/03

Улаанбаатар хот

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3, 60.4, 67 дугаар зүйлийн 67.1, Компанийн дүрмийн 7.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Атар өргөө” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 08:30 цагаас компанийн байр (Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 20, “Атар өргөө” ХК-ийн байрны хурлын танхим)-д хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурьдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.  
Үүнд:
  - Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
  - Компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах
  - Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын даргад

Б.Мөнхдалай

ТУЗ-ийн дарга

Гишүүдэд

Б.Ханхүслэн

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

4. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст даалгах нь:



- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зар мэдээг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ( өдөр тутмын сонин, телевиз ) болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудас бусад мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх
  - Энэхүү мэдээллийг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх
  - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай мэдэгдлийг холбогдох бичиг баримтын хамт Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн дотор хүргүүлэх
  - Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал тэдгээрийн танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөл, санал авах хуудсыг үнэт цаасны брокер, диллерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2025 оны 03 дугаар сарын 26-ны дотор хүргүүлэх
  - Хурлаас хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс мөн оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10-13, 14-17 цагт компанийн байранд хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, саналын хуудсаар санал авах
5. Хурал зарласан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд дор дурьдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх зохион байгуулах комисст зөвшөөрсүгэй. Үүнд:
- Компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайлан
  - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлт
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга
  - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал
  - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд холбогдох бусад мэдээлэл
6. Ээлжит хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
7. Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
8. Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүлээж авах сүүлийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Мөнхдалайг сонгосугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 03 дугаар сарын 17 өдрийн 01 дугаар шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар Ц.Энхтүвшин, гишүүнээр А.Бадамгарав, Д.Гүнжидмаа нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ